



МОНГОЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ  
ГИШҮҮН ХОРШООДОД ҮЗҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Монголын хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад туслах, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гишүүдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор МХЗХҮХ-ны гишүүн ХЗХ-дод шаардлагатай чиглэлээр арга зүйн, зөвлөгөө үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 МХЗХҮХ нь Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн 52.1.3; 53.1.1; 53.1.3; 53.1.4 дэх заалтууд, холбооны дүрмийн 3.1.1-3.1.5 дахь заалтуудыг үндэслэл болгон энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

Холбоо нь дараах төрлийн зөвлөх үйлчилгээг гишүүн ХЗХ-дод үзүүлнэ.

**2.1 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ-** нь гишүүн хоршоодын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөнд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр гишүүн хоршоодтой байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх үйлчилгээ. Дараах төрлийн үйлчилгээг үзүүлнэ:

- 2.1.1 **НЭГ УДААГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ** - Гишүүн хоршооны нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлagnalyg сайжруулах талаар арга зүйн зөвлөгөөг гишүүн ХЗХ-ны хүсэлтээр “ХЗХ-ны нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө үйлчилгээ”-ны гэрээг үндэслэн холбооны зүгээс тухай бүр үзүүлэх 1 удаагийн үйлчилгээ.
- 2.1.2 **БАЙНГЫИН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ** - Шинээр байгуулагдсан ХЗХ-дыг санхүүгийн чадавхитай болох хүртэлх тодорхой хугацаанд нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлagnalд туслалцаа үзүүлэх “Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх” байнгын гэрээг үндэслэн сар бүрийн санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын тайлан, зээл, хадгаламж, хувь хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан, улирал тутмын СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, татварын тайлан, санхүүгийн тайлангуудыг бэлтгэж өгөх үйлчилгээ.
- 2.1.3 **НББ-ЫН ШААРДЛАГАТАЙ МАЯГТ НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ** - НББүртгэл хөтлөлтөнд шаардлагатай маягуудыг нэгдсэн байдлаар хэвлүүлж өртөг багатай нэгдсэн маягаар гишүүн хоршоодыг хангах үйлчилгээг “Маягт нийлүүлэх гэрээ”-ний дагуу гишүүн хоршооны хүсэлтээр үзүүлнэ.

**2.2 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨХ, ҮЙЛЧИЛГЭЭ** - Гишүүн хоршоодод хууль эрхзүйн зөвлөгөө, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх үйлчилгээ. Дараах төрлийн зөвлөх үйлчилгээг гишүүн хоршоодод үзүүлнэ:

- 2.2.1 **ХУУЛЬ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ** – Гишүүн хоршооны хүсэлтээр хоршооны үйл ажиллагаанд шаардлагатай хууль зүйн баримт бичгийн эх боловсруулах, мөрдөж ажиллаж байгаа дүрэм, журам, гэрээний загваруудад мэргэжлийн дүгнэлт, зөвлөгөө өгөх.
- 2.2.2 **ШҮҮХЭД ТӨЛӨӨЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ** – Гишүүн хоршооны нэрийн өмнөөс хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар шүүхэд төлөөлөх үйлчилгээ. Үүнд: шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх хуралд оролцох, шийдвэр гарсаны дараа шийдвэр гүйцэтгэлийн гэрээ хийх гэх мэт.
- 2.2.3 **ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ** – Гишүүн хоршоодын хүссэн чиглэлээр хууль эрх зүйн зөвлөгөө үйлчилгээг гэрээний үндсэн дээр үзүүлэх үйлчилгээ.

- 2.3 БУСАД ЗӨВЛӨГӨӨ УЙЛЧИЛГЭЭ** – Гишүүн хоршоодын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, засаглал, санхүү, менежмент, маркетингийн чиглэлээр заавар зөвлөгөөг гишүүн хоршооны хүсэлтээр гэрээ байгуулан үзүүлэх үйлчилгээ.

### **ГУРАВ. ЗӨВЛӨХ УЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 3.1 Гишүүн хоршоодод зөвлөх үйлчилгээг чанартай хүргэх үүднээс Зөвлөгөө, үйлчилгээний дэд хороо энэхүү журмын 3.4-т заасан шаардлагыг хангасан “зөвлөх”-өөр ажиллах боломжтой хүмүүсийг тодорхойлж Гүйцэтгэх захиралд санал болгоно.
- 3.2 Гүйцэтгэх захирал нь хоршоодтой зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахдаа гишүүн хоршооны саналыг үндэслэн зөвлөхийг сонгож ажиллуулна.
- 3.3 Энэхүү журмын дагуу зөвлөхөөр ажиллах хүсэлтэй мэргэжилтэн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Хадгаламж, зээлийн хоршооны салбарт тухайн зөвлөх чиглэлээрээ 5-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай,
  - Мэргэжлийн өндөр зэрэгтэй, мэргэшсэн эсвэл бакалавраас дээш зэрэгтэй,
  - Салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй.
- 3.4 Дээрх шаардлагыг хангаж байгаа, зөвлөхөөр ажиллах хүсэлтэй хүмүүс дараах баримт бичгийг бүрдүүлж холбооны гүйцэтгэх захирлаар дамжуулан зөвлөгөө үйлчилгээний дэд хороонд хүргүүлнэ. Үүнд:
- Зөвлөхөөр ажиллах хүсэлт,
  - Анкет,
  - Иргэний үнэмлэхний хуулбар,
  - Мэргэжил боловсролын зэргийг нотлох диплом, үнэмлэхний хуулбар,
  - Ажиллаж байгаа эсвэл байсан ХЗХ-ны тодорхойлолт /зөвлөхөөр ажиллах ур чадвартайг тодорхойлсон/

### **ДӨРӨВ. ЗӨВЛӨХ УЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ҮНЭ ТАРИФ**

- 4.1. Энэхүү журмын хавсралтаар Тэргүүлэгчдийн зөвлөлөөс батлагдсан үйлчилгээний үнэ тарифийг үндэслэн зөвлөх үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 4.2. Зөвлөх үйлчилгээний гэрээний нийт үнийн дүнгийн 20% - иас доошгүй нь холбооны цэвэр орлого байна.
- 4.3. Зөвлөх үйлчилгээний тарифыг Тэргүүлэгчдийн зөвлөлөөс жил бүр зах зээлийн нөхцөл, инфляцийг харгалzan шинэчлэн тогтоож болно.

### **ТАВ. ЗӨВЛӨХ УЙЛЧИЛГЭЭН ДЭХ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

- 5.1. Зөвлөх үйлчилгээ авахыг хүссэн хоршоо нь сонгосон зөвлөхтэй байгуулах гэрээндээ талуудын үүрэг, хариуцлагаа тодорхойлж баталгаажуулсан байна.
- 5.2. Зөвлөх үйлчилгээтэй холбогдсон аливаа маргаан үүсвэл талууд байгуулсан гэрээний заалтыг баримтлан аль болох ойлголцон шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

\*\*\*\*\*